

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024 /312/ НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас:70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас:70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

"Голден пэйж Аудит" ХХК захирал: С.Оюунгэрэл
Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/77

танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн тодруулга тайланг бэлтгэж аудитад ирүүлээгүй, бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 63,308.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтгүй, үнийн харьцуулалтгүй, барааны нэр төрөл, үнийн дүнг ил тод мэдээлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 50 дугаар зүйлийн 50.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ”, 50.1.1-д “шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 50.1.2-т “төрийн ашиг сонирхлыг дээдлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

019020084

Асуудлыг онцолсон хэсэг

Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 92,694.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэл нь 92,8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>114,742,036.14</u> | <u>100,835,119.27</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 71,774,747.94 | 57,376,047.07 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 71,774,747.94 | 57,376,047.07 |
| 3121 | Төгрөг | 71,774,747.94 | 57,376,047.07 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 71,774,747.94 | 57,376,047.07 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 42,967,288.20 | 43,459,072.20 |
| 351 | Түүхий эд материал | 90,000.00 | 00.00 |
| 354 | Хангамжийн материал | 42,877,288.20 | 43,459,072.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 234,600.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 42,311,038.20 | 39,102,195.20 |
| 35460 | Хүнсний материал | 331,650.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 4,356,877.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>890,035,886.02</u> | <u>869,728,542.31</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 890,035,886.02 | 869,728,542.31 |
| 392 | Биет хөрөнгө | 871,955,886.02 | 851,648,542.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 896,050,431.00 | 896,050,431.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (60,644,359.75) | (80,726,243.15) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 46,818,331.00 | 48,070,081.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,828,508.28) | (31,318,172.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,014,836.41 | 42,905,336.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (20,589,940.47) | (24,278,625.51) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,061,450.00 | 2,061,450.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (926,353.89) | (1,115,714.97) |
| 393 | Биет бус хөрөнгө | 18,080,000.00 | 18,080,000.00 |
| 39301 | Программ хангамж | 100,000.00 | 100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (100,000.00) | (100,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,080,000.00 | 18,080,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,004,777,922.16</u> | <u>970,563,661.58</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,004,777,922.16</u> | <u>970,563,661.58</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,004,777,922.16 | 970,563,661.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 247,716,328.94 | 247,716,328.94 |
| 51101 | Өмч: - төрийн | 247,716,328.94 | 247,716,328.94 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 691,039,933.09 | 656,825,672.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 691,039,933.09 | 691,039,933.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | (34,214,260.58) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 66,021,660.13 | 66,021,660.13 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,004,777,922.16</u> | <u>970,563,661.58</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 446,292,690.00 | 450,937,277.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,555,190.00 | 11,429,777.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,555,190.00 | 11,429,777.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,984,790.00 | 5,864,377.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,984,790.00 | 5,864,377.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 181,048,200.00 | 439,507,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 107,846,100.00 | 387,663,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 107,846,100.00 | 387,663,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 257,689,300.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,071,400.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,071,400.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 62,130,700.00 | 51,844,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 62,130,700.00 | 51,844,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 381,059,450.10 | 484,907,557.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 381,059,450.10 | 484,907,557.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 371,306,393.08 | 484,850,635.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 232,272,910.48 | 300,441,550.47 |
| 210101 | Үндсэн цалин | 185,862,318.87 | 231,030,114.18 |
| 210102 | Нэмэгдэл | 33,414,125.56 | 61,260,909.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 12,996,466.05 | 8,150,527.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,220,710.71 | 38,020,509.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,905,040.15 | 25,963,315.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,330,181.97 | 3,058,261.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,864,365.56 | 2,402,609.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 460,357.21 | 589,798.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,660,765.82 | 6,006,523.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,495,162.94 | 50,787,377.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,993,881.19 | 4,997,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,317,281.75 | 43,089,477.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,184,000.00 | 2,700,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 165,500.00 | 5,195,363.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 165,500.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 5,195,363.00 |
| 2105 | Нормативд зардал | 39,814,505.00 | 45,229,129.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,767,305.00 | 45,229,129.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 47,200.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 500,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 1,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 604,000.00 | 955,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 604,000.00 | 955,000.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|------------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,233,603.95 | 43,221,705.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,728,600.00 | 11,858,290.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,134,000.00 | 2,960,672.00 |
| 210903 | үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,371,003.95 | 28,402,743.71 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,753,057.02 | 56,922.32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,571,400.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,571,400.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,181,657.02 | 56,922.32 |
| 213404 | Хөрөнгийн | 1,181,657.02 | 56,922.32 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 65,233,239.90 | (33,970,280.58) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 243,980.00 |
| 225005 | үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 243,980.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | (243,980.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 65,233,239.90 | (34,214,260.58) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|-------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>313,340,800.00</u> | <u>439,507,500.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 313,340,800.00 | 439,507,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 387,663,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 387,663,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 257,689,300.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,571,400.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 47,080,100.00 | 51,844,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,080,100.00 | 51,844,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>252,458,084.93</u> | <u>453,849,278.55</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 252,458,084.93 | 453,849,278.55 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 243,886,684.93 | 453,849,278.55 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 167,765,317.04 | 300,416,498.65 |
| 210101 | Үндсэн цалин | 135,314,801.04 | 214,166,275.24 |
| 210102 | Нэмэгдэл | 22,458,041.55 | 76,436,378.10 |
| 210104 | Урамшуулал | 9,992,474.45 | 9,813,845.31 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,027,016.45 | 38,045,561.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,335,610.62 | 24,791,461.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,674,115.80 | 3,313,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,339,512.62 | 2,650,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 329,143.93 | 662,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,348,633.48 | 6,627,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,523,201.44 | 50,787,377.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,699,901.19 | 4,997,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,823,300.25 | 43,089,477.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 2,700,000.00 |
| 2105 | Нормативд зардал | 22,121,300.00 | 44,804,479.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,121,300.00 | 44,804,479.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 500,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 1,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 408,000.00 | 923,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 408,000.00 | 923,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,541,850.00 | 17,871,662.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,292,450.00 | 15,093,562.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,249,400.00 | 2,778,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,571,400.00 | 00.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,571,400.00 | 00.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>60,882,715.07</u> | <u>(14,341,778.55)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 60,882,715.07 | (14,341,778.55) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 71,774,747.94 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 60,882,715.07 | 57,376,047.07 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 247,716,328.94 | 66,021,660.13 | 632,584,413.59 | 946,322,402.66 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 247,716,328.94 | 66,021,660.13 | -313,689,421.81 | 48,567.26 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,004,729,354.90 | 1,004,729,354.90 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 247,716,328.94 | 66,021,660.13 | 691,039,933.09 | 1,004,777,922.16 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 247,716,328.94 | 66,021,660.13 | 691,039,933.09 | 1,004,777,922.16 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (34,214,260.58) | (34,214,260.58) |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 247,716,328.94 | 66,021,660.13 | 656,825,672.51 | 970,563,661.58 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 63,733,600 | 53,787,482 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 63,733,600 | 53,787,482 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 63,733,600 | 53,787,482 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 44,515,600 | 41,587,523 |
| 210101 | Үндсэн цалин | 34,448,000 | 29,521,458 |
| 210102 | Нэмэгдэл | 10,067,600 | 11,615,585 |
| 210104 | Урамшуулал | - | 450,479 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,564,400 | 5,198,440 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,784,000 | 3,418,040 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 445,200 | 445,200 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 356,000 | 356,000 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 89,000 | 89,000 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 890,200 | 890,200 |
| 2105 | Нормативд зардал | 11,632,100 | 5,036,759 |
| 210502 | Хоол, хүнс | 11,632,100 | 5,036,759 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 111,100 | 100,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 111,100 | 100,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,910,400 | 1,864,760 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 521,300 | 521,300 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,389,100 | 1,343,460 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 63,733,600 | 63,733,600 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 63,733,600 | 63,733,600 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 63,733,600 | 63,733,600 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 71,774,748 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 86,189,185 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 19 | 19 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 9 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Алтанбулаг сумын цэцэрлэг нь 1960 онд 1 багш 1 бүлэгтэйгээр Хөдөлмөр нэгдлийн хөрөнгөөр орон сууцны байранд анх байгуулагдсан. 1973 онд улсын цэцэрлэг болсон ба эрхлэгч, 2 багш ажиллаж байсан. 2004 онд аймгийн ЗДТГ, Английн хүүхдийг ивээх сангийн хамтарсан хөрөнгөөр өөрийн гэсэн зориулалтын байртай болж 2 бүлэгт 50 хүүхэдтэй, 1 эрхлэгч 2 багш, 1 туслах багш, 1 тогооч, галч нийт багш ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

2021 онд өргөтгөл хийн 175 хүүхдийн хүчин чадал бүхий хичээлийн 2 байртай болж өргөжин үйл ажиллагаа явуулж байна

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхэд, багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагч бүр нээлттэй, шударга, хариуцлагатай байх, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд багш, эцэг эхийг бүтээлчээр оролцох боломжийг хангах, хүүхдийн сурч хүмүүжих орчныг аюулгүй байлгах гэж тодорхойлсон.

Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь Төв аймгийн Засаг даргын 2013 оны 10 дүгээр сарын 11 өдрийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн 0000919 тоот гэрчилгээтэй. Сургалт эрхлэх хугацааг 2028 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл сунгасан байна

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 01 дүгээр сарын 2023 оны А/01 тушаалаар батлагдсан 21 орон тоо бүтэцтэй ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,214.2 мянган төгрөгөөр буюу 17.9 хувир буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|------------------|-------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 71,774.7 | 57,376.0 | (14,398.7) |
| Бараа материал | 42,967.3 | 43,459.1 | 491.8 |
| Үндсэн хөрөнгө | 890,035.9 | 869,728.5 | (20,307.4) |
| Нийт хөрөнгө | 1,004,777.9 | 970,563.7 | (34,214.2) |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,004,777.9 | 970,563.7 | (34,214.2) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,004,777.9 | 970,563.7 | (34,214.2) |

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 20,0 хувиар буурсан
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1,1 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 42,967.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 57,160.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 5,810.4 мянган төгрөг нийт 63,024.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 62,532.9 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 43,459.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 890,035.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд худалдан авсан 2,530.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 5,565.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмж, 2,953.2 мянган төгрөгийн хөрөнгийг актлан хасаж бүртгэсэн байна. Нийт үндсэн хөрөнгө 20,307.4 мянган төгрөгөөр буурсан байна.

- Өглөгийн талаар: Тайлант хугацааны эцэст өр төлбөр үүсээгүй байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 34,214.2 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 431,491.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 431,491.2 мянган төгрөгөөр тооцон 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/82 албан тоотоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 58,800.6 мянган төгрөгөөр бууруулж, 372,690.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсрол-71801 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 459,438.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 402,062.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 402,062.1 мянган төгрөг буюу ,87.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 57,376.1 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|------------|-----------|----------|---------|
| 1 | Сургуулийн өмнөх боловсрол-71801 | 459,438.0 | 402,062.1 | 57,376.1 | 87.5% |
| 1.1 | Эрүүл мэндийг дэмжих-80605 | 1,389.1 | 1,122.2 | 366.9 | 80.7% |
| 1.2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол-81807 | 58,146.4 | 44,804.5 | 13,341.9 | 77.05% |
| 1.3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816 | 4,197.0 | 4,197.7 | 0.0 | 100% |
| 1.4 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823 | 1,438.9 | 1,438.0 | 0.9 | 99.9% |
| 1.5 | Явуулын багшийн үйлчилгээ-81833 | 6,528.0 | 5,875.2 | 652.8 | 90.0% |
| 1,6 | Боловсролын стандарт, сургалт-81834 | 302,725.4 | 268,932.7 | 22,562.0 | 88.8% |
| 1.7 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835 | 85,013.2 | 75,691.7 | 9,321.5 | 89.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр 51,844.3 мянган төгрөгийн санхүүжилт авч байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал зардалд олгосон байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр 87.5 хувиар хэрэгжсэн байна

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч, Д.Энх-амгалан, Ө.Бат-оюун нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 1,004,777.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 15,071.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,303.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, боломжит зардлыг тэвчиж ажилласнаар нэмэгдэл цалингийн зардлыг 3,378.5 мянган төгрөг, шимтгэлийг 365.9 мянган төгрөг, хоол хүнсний зардлыг 6,595.4 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлыг 45.7 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Шилэн дансанд 2023 онд нийт 154 мэдээллийг хугацаанд нь байршуулж хугацаа хоцроож 3 мэдээлэл мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Хустайн мандал ХХК-д мөнгөн хөрөнгөөс 48,6426.3 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд 23,488.3 мянган төгрөг шилжүүлсэн мэдээлэл байршуулж 25,154.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяа”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 42,711.5 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 247,716.3 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо 205,004.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Бараа материал худалдан авалт хийх, бэлтгэхдээ үнийн харьцуулалт хийгээгүй, хэдэн төгрөгөөр ямар төрлийн бараа үйлчилгээ авах нь тодорхойгүй, гэрээ байгуулан гэрээний үүргийн хяналтыг хэрэгжүүлээгүй, сумын Засаг даргын Тамгын газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг гэсэн хэдий ч хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй давуу байдал бий болсон, албан тушаалтан шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлээгүй, төрийн ашиг сонирхлыг дээдлэн ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэнтэй нийцээгүй. мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасан “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 50-р зүйлийн 50.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ”, 50.1.1-д “шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 50.1.2-т “төрийн ашиг

сонирхлыг дээдлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн зохистой байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ил тод нээлттэй явуулаагүй, ашиг сонирхол албан тушаалын давуу байдал үүссэн байна. ТБӨНОХБАҮХА тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар цахим баримтын бүрдэл, цалингийн тооцоо, улсын бүртгэлийн хөрөнгийн дүн, зөрүүтэй зөрчлүүд, шилэн дансны талаар 2 зөрчил нийт 5 зөрчил ирүүлэн асуудлын бүртгэл хүргүүлсэн, хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар 497.9 мянган төгрөгийн 1 актын төлбөр барагдуулсан, 1,975.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага 50 хувийн биелэлттэй, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | | | |
|-----------------|------------------------|----------------|---------|----------------|-------------|
| | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 497.9 | 1 | 497.9 | 100 |
| Албан шаардлага | 1 | 1,975.4 | 1 | 987.7 | 50 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100 |
| Нийт дүн | | 2,473.3 | | 1,485.6 | 83.3 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж хуулийн хугацаанд нь аудитад ирүүлдэг байх, санхүүгийн тодруулга толилуулгыг үнэн зөв бэлтгэдэг байх
2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв, шударга, ил тод хийдэг байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,447.22 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

5.2.1 Худалдан авах ажиллагааны талаар

Илрүүлэлт: Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 63,308.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтгүй, үнийн харьцуулалтгүй, барааны нэр төрөл, үнийн дүнг ил тод мэдээлээгүй, ил тод байх, нээлттэй байх, мэдээллээр хангах зарчмыг баримтлаагүй байгаа нь мөрдөөгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д заасан “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 50-р зүйлийн 50.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ”, 50.1.1-д “шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 50.1.2-т “төрийн ашиг сонирхлыг дээдлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн зохистой байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Анхан шатны баримтын талаар

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны Цахим баримтын бүрдэлд 22,084.3 мянган төгрөгийн цахим баримт илүү, 75.6 мянган төгрөгийн баримт дутуу шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана” гэсэн заалтуудтай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.3 Удирдлагын тайлагналын талаар

Илрүүлэлт: Төсвийн захирагч болон нягтлан бодогч нь эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, сум орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган, хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал шуурхай байдлыг эрхэмлэн ажиллахыг үүрэг болгосон. Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан ирүүлээгүй, санхүүгийн тодруулга тайлан бэлтгээгүй байгаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шалгуурт нийцсэн байх, санхүүгийн ухаалаг удирдлага болон төрийн албан хаагчийн зан үйл зүй зохистой байх, хариуцлагатай байх гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн нэмэлт санхүүжилтээр 51,844.3 мянган төгрөг хүлээн авснаас гэрэл цахилгаанд 4,997.9 мянган төгрөг, халаалтад 43,087.5 мянган төгрөг, цэвэр бохир усанд 2,700.0 мянган төгрөг зарцуулсан. Цахим баримт, мөнгөн хөрөнгийн журналаар гэрэл цахилгаанд 6,174.9 мянган төгрөг, халаалтад 40,724.5 мянган төгрөг, цэвэр бохир усанд 3,888.0 мянган төгрөг тус тус зарцуулсан. Гэрэл цахилгаанд 1,177.0 мянган төгрөг илүү, халаалтад 2,363.0 мянган төгрөг дутуу, юунд 1,188.0 мянган төгрөг илүү байгаа нь төсвийг үндэслэлтэй үнэн батлуулдаггүй, хариуцлагатай байх зарчим алдагдсан. Санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг бодитой, үнэн зөв үндэслэлтэй батлуулдаг байх, хариуцлагатай байх

5.3.2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооны хүснэгтээр олгох цалин 242,093.4 мянган төгрөг, харилцахын хуулгаар гарт олгосон цалин 242,344.1 мянган төгрөг гарт олгох дүн 250.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь. Санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлэн ажиллах

Өгсөн зөвлөмж: Тооцооллын алдаагүй, үнэн зөв бүртгэж, тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|-----------------------------------|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааны талаар | 1 | 63,308.7 | | | 1 | 63,608.7 | | | | | | |
| Анхан шатны баримтын талаар | 1 | 22,159.8 | | | 1 | 22,159.8 | | | | | | |
| Удирдлагын тайлагналын талаар | 1 | | | | 1 | | | | | | | |
| Цалин хөлсийг илүү олгосон | 1 | 250.7 | | | | | 1 | 250.7 | | | | |
| Нэмэлт төсвийг зөрүүтэй мэдээлсэн | 1 | 4,728.0 | | | | | 1 | 4,728.0 | | | | |
| Дүн | 5 | 90,447.2 | | | 3 | 85,468.5 | 2 | 4,978.7 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг | 1 | 25,154.0 | | | 1 | 25,154.0 | | |
| Мэдээллийг бүрэн оруулж байх | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 2 | | | | 1 | 25,154.0 | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Улсын бүртгэлийн талаар | 1 | 205,004.8 | | | | | 1 | 205,004.8 |
| Худалдан авах ажиллагааны талаар | 1 | | | | 1 | | | |
| Дүн | 2 | 205,004.8 | | | 1 | | 1 | 205,004.8 |
| Нийт дүн | 4 | 230,158.8 | | | 2 | 25,154.0 | 2 | 205,004.8 |



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 40-14510516-ТӨА-2024

Зуунмод

347/НА-ЛТА-ТШС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримтын бүрдэлд 22,084,300 /хорин хоёр сая наян дөрвөн мянга гурван зуун/ төгрөгийн цахим баримт илүү, 75,600 /далан таван мянга зургаан зуун/ төгрөгийн баримт дутуу шивэгдсэн зөрүүтэй бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

01001058

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Г.Баасанжаргал, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582